ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорноговь аймгийн Сайншанд сумын 6-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/148НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-б/236

танай___________-ны №___________-т

САЙНШАНД СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ П.ЦЭЦЭГДЭЛГЭР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад

010020060

Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай нийт 20 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, хугацаа хоцроосон, буруу мэдээлсэн зэрэг алдаа гаргасан байна.

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 39 ширхэг 66.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 20 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байна.

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 85.6 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **68,526,131.09** | **141,491,330.84** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **21,009,330.51** | **94,608,917.26** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **21,009,330.51** | **94,608,917.26** |
| **31210** | **Төгрөг** | **21,009,330.51** | **94,608,917.26** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 9,402,418.43 | 75,825,894.18 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 11,606,912.08 | 18,783,023.08 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **47,516,800.58** | **46,882,413.58** |
| **35100** | **Түүхий эд материал** | **17,681,154.08** | **13,988,186.08** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,272,754.08 | 12,579,786.08 |
| 35130 | Эм боох материал | 1,408,400.00 | 1,408,400.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **29,835,646.50** | **32,894,227.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,705,250.00 | 1,968,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,148,427.50 | 24,620,947.50 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,032,400.00 | 1,192,450.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,536,669.00 | 4,730,380.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 412,900.00 | 381,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **616,808,650.73** | **585,289,685.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **616,808,650.73** | **585,289,685.88** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **587,851,109.16** | **556,791,394.27** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 648,870,529.88 | 648,870,529.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -95,859,847.99 | -121,782,434.71 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 46,189,563.00 | 44,162,163.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,441,411.51 | -27,221,364.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,726,942.00 | 14,778,262.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,718,744.45 | -3,452,359.31 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 442,189.95 | 442,189.95 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -386,428.38 | -414,309.06 |
| 39217 | Ном | 1,028,316.66 | 1,408,716.66 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **28,957,541.57** | **28,498,291.61** |
| 39301 | Програм хангамж | 3,176,500.00 | 2,002,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,538,958.43 | -1,823,708.39 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,320,000.00 | 28,320,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **685,334,781.82** | **726,781,016.72** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **804,250.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **804,250.00** |
| **41300** | **Өглөг** | **0.00** | **804,250.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **804,250.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 694,250.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 110,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **685,334,781.82** | **725,976,766.72** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **685,334,781.82** | **725,976,766.72** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 204,549,706.52 | 204,549,706.52 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 204,549,706.52 | 204,549,706.52 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **177,508,344.58** | **218,150,329.48** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -481,823,925.16 | 177,508,344.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 659,332,269.74 | 40,641,984.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 303,276,730.72 | 303,276,730.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **685,334,781.82** | **726,781,016.72** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,098,889,207.16** | **577,087,076.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **695,569,306.04** | **5,744,924.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **695,569,306.04** | **5,744,924.25** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **4,591,813.00** | **5,364,524.25** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | 126,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,488,313.00 | 5,238,524.25 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 651,003,693.94 | 380,400.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 39,973,799.10 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,319,901.12** | **571,342,152.43** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **339,542,500.00** | **518,614,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 339,542,500.00 | 518,614,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **210,000.00** | **0.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 210,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,567,401.12** | **52,727,652.43** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,567,401.12 | 52,727,652.43 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **438,294,219.42** | **536,445,091.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **438,294,219.42** | **536,445,091.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **434,144,219.42** | **532,495,091.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **275,429,104.36** | **347,557,492.63** |
| 210101 | Үндсэн цалин | 213,281,017.95 | 240,415,822.09 |
| 210102 | Нэмэгдэл | 54,002,069.41 | 94,788,457.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 8,146,017.00 | 12,353,213.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **34,843,805.71** | **44,078,620.62** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,909,387.76 | 30,218,042.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,793,344.86 | 3,514,246.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,228,565.66 | 2,771,737.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 534,295.02 | 688,644.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,378,212.41 | 6,885,949.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **44,328,808.76** | **50,227,652.43** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,808,612.76 | 6,534,112.43 |
| 210302 | Түлш, халаалт | 35,035,000.00 | 38,878,840.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,485,196.00 | 4,814,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,892,290.52** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 250,700.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал | 445,000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,196,590.52 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,532,018.00** | **35,459,789.00** |
| 210502 | Хоол, хүнс | 26,522,018.00 | 35,459,789.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **560,600.00** | **1,829,630.00** |
| 210604 | Урсгал засвар | 560,600.00 | 1,829,630.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **814,000.00** | **713,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 814,000.00 | 713,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **48,743,592.07** | **52,628,907.10** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,285,633.86 | 13,571,718.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,037,320.00 | 1,919,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,420,638.21 | 37,137,889.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,150,000.00** | **3,950,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,150,000.00** | **3,950,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,150,000.00 | 3,950,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **660,594,987.74** | **40,641,984.90** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,262,718.00** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 1,262,718.00 | 0.00 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 659,332,269.74 | 40,641,984.90 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **420,925,913.20** | **583,544,213.43** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **17,816,012.08** | **12,202,061.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **17,816,012.08** | **12,202,061.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **17,816,012.08** | **126,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 313,500.00 | 126,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 17,502,512.08 | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 12,076,061.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,109,901.12** | **571,342,152.43** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **339,542,500.00** | **518,614,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 339,542,500.00 | 518,614,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,567,401.12** | **52,727,652.43** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,567,401.12 | 52,727,652.43 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **399,916,582.69** | **509,944,626.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **399,916,582.69** | **509,944,626.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **395,766,582.69** | **505,994,626.68** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **280,229,104.36** | **359,853,601.51** |
| 210101 | Үндсэн цалин | 218,081,017.95 | 252,711,930.97 |
| 210102 | Нэмэгдэл | 54,002,069.41 | 94,788,457.17 |
| 210104 | Урамшуулал | 8,146,017.00 | 12,353,213.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **34,843,805.71** | **43,858,572.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,823,100.00 | 29,992,691.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,738,054.87 | 3,510,925.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,250,009.73 | 2,769,321.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 540,567.96 | 674,904.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,492,073.15 | 6,910,729.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **44,328,808.76** | **50,227,652.43** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,808,612.76 | 6,534,112.43 |
| 210302 | Түлш, халаалт | 35,035,000.00 | 38,878,840.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,485,196.00 | 4,814,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,244,060.00** | **36,614,500.00** |
| 210502 | Хоол, хүнс | 21,244,060.00 | 36,614,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **398,800.00** | **2,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 398,800.00 | 2,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **814,000.00** | **713,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 814,000.00 | 713,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,908,003.86** | **12,227,300.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,128,003.86 | 9,966,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,780,000.00 | 2,261,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,150,000.00** | **3,950,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,150,000.00** | **3,950,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,150,000.00 | 3,950,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **21,009,330.51** | **73,599,586.75** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **21,009,330.51** | **73,599,586.75** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 21,009,330.51 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 21,009,330.51 | 94,608,917.26 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **-481,823,925.16** | **26,002,512.08** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **-481,823,925.16** | **26,002,512.08** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **659,332,269.74** | **659,332,269.74** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **177,508,344.58** | **685,334,781.82** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **177,508,344.58** | **685,334,781.82** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **177,508,344.58** | **685,334,781.82** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 40,641,984.90 | 40,641,984.90 |
| **20** | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **204,549,706.52** | **303,276,730.72** | **218,150,329.48** | **725,976,766.72** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **528,142,200.00** | **452,317,024.25** | **75,825,175.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **528,142,200.00** | **452,317,024.25** | **75,825,175.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **528,142,200.00** | **452,317,024.25** | **75,825,175.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **421,271,900.00** | **359,853,601.51** | **61,418,298.49** |
| 210101 | Үндсэн цалин | 284,708,300.00 | 252,711,930.97 | 31,996,369.03 |
| 210102 | Нэмэгдэл | 124,733,400.00 | 94,788,457.17 | 29,944,942.83 |
| 210104 | Урамшуулал | 11,830,200.00 | 12,353,213.37 | -523,013.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **52,838,200.00** | **43,858,572.74** | **8,979,627.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,987,700.00 | 29,992,691.11 | 5,995,008.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,212,600.00 | 3,510,925.54 | 701,674.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,370,000.00 | 2,769,321.94 | 600,678.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 842,600.00 | 674,904.77 | 167,695.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,425,300.00 | 6,910,729.38 | 1,514,570.62 |
| **2105** | **Нормативт зардал** | **41,456,800.00** | **36,614,500.00** | **4,842,300.00** |
| 210502 | Хоол, хүнс | 41,456,800.00 | 36,614,500.00 | 4,842,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **753,800.00** | **713,000.00** | **40,800.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 753,800.00 | 713,000.00 | 40,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,821,500.00** | **11,277,350.00** | **544,150.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,560,000.00 | 9,016,250.00 | 543,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,261,500.00 | 2,261,100.00 | 400.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **528,142,200.00** | **518,740,500.00** | **9,401,700.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **518,614,500.00** | **518,614,500.00** | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 518,614,500.00 | 518,614,500.00 | 0.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **9,527,700.00** | **126,000.00** | **9,401,700.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 126,000.00 | 126,000.00 | 0.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 9,401,700.00 | 0.00 | 9,401,700.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 9,402,418.43 | -9,402,418.43 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 75,825,894.18 | -75,825,894.18 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 314.4 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 314.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулллаа.

Залруулсан алдаа:

1. Ажлаас гарсан ажилтны ээлжийн амралтын тооцоог журналын бичилтэд дутуу хийсэнтэй холбоотой 161.2 мянган төгрөгийн,
2. Ээлжийн амралтаас ҮЭ-1%-ийн суутгалыг тохируулах бичилтээр хаасантай холбоотой 153.3 мянган төгрөгийн

Аудитаар нийт 4 зөрчил[2] илэрснээс 68,655.1 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага тогтоогоогүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт1*: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай нийт 20 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, хугацаа хоцроосон, буруу мэдээлсэн зэрэг алдаа гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж1*:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудын дагуу тогтмол, хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэвших

*Илрүүлэлт2*: Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т "Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж2*: 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

*Илрүүлэлт3*: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 39 ширхэг 66.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 20 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж3*: И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад

талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажлаас гарсан ажилтны ээлжийн амралтын тооцоог журналын бичилтэд дутуу хийсэнтэй холбоотой 161.2 мянган төгрөгийн, | 1 | 161.2 | 0 | - | 1 | 161.2 | 1 | 161.2 | 0 | . | | |
| Ээлжийн амралтаас ҮЭ-1%-ийн суутгалыг тохируулах бичилтээр хаасантай холбоотой 153.3 мянган төгрөгийн | 1 | 153.3 | 0 | - | 1 | 153.3 | 1 | 153.3 | 0 | | | |
| Дүн | 2 | 314.5 | - | - | 2 | 314.5 | 2 | 314.5 | - | - | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл -байхгүй

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай нийт 20 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, хугацаа хоцроосон, буруу мэдээлсэн зэрэг алдаа гаргасан байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| : Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 39 ширхэг 66.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 20 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан | 1 | | | | | | 1 | |
| Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 2 | | | | | | 2 | |
| Нийт дүн | 3 | | | | | | 3 | |